



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

“Дипломат байгууллагын үйлчилгээг  
эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын  
2018 оны үйл ажиллагаа, эдийн  
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон  
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх  
хэсэг, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай  
контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн  
ТОГТООХ нь:

1.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит  
үйлдвэрийн газрын 2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт,  
зорилтот түвшний болон захирал Ё.Нямжавтай байгуулсан 2018 оны контрактын  
биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит  
үйлдвэрийн газрын захирал Ё.Нямжавтай 2019 онд 1 жилийн хугацаатай контракт  
байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Бодлого төлөвлөлт,  
удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. Төрийн өмчийн үйлдвэрийн газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн  
болон зорилтот түвшний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт,  
удирдлагын хэлтсэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000319